

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1 Төслийн товч мэдээлэл.....	3
1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	3
1.3 Төслийн хүчин чадал.....	3
1.4 Ашиглалтын систем	3
1.5 Дэд бүтэц	3
Уурхайн барилга байгууламж, дэд бүтцийн бүрэлдэхүүнд:	3
Цахилгаан үүсгүүрийн газардуулгын тооцоо:.....	4
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙН ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	6
2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газар зүйн нөхцөл.....	6
2.2 Уурхайн тээвэр	7
2.3 Овоолгын ажил	8
2.4 Тоосго үйлдвэрлэх ерөнхий дамжлага	8
Тоосго үйлдвэрлэх технологийн тоо чанарын схем	9
Бүтээгдэхүүн гаргалт:.....	10
2.5 Тоосго үйлдвэрлэх тоног төхөөрөмж	11
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	12
2.1 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	12
2.1.1 Агаарын чанар	12
Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	12
2.1.2 Хөрсөн бүрхэвч.....	12
Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	12
2.1.3 Гадаргын болон газрын доорх ус	13
2.1.4 Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл	13
Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	13
2.1.5 Ургамлан нөмрөг	14
Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	14
2.1.6 Амьтны аймаг	14
Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	14
2.1.7 Нийгэм эдийн засаг	14
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	15
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
БҮЛЭГ 8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	20
БҮЛЭГ 9. ХОГ, ХАЯГДАЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	21
БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	22
БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	24
БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ	25

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн товч мэдээлэл

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших MV-020497 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Харгана т-3” тоосгоны шаврын ордиг ил аргаар ашиглах төслийн техник эдийн засгийн үндэслэлийг ЭБМЗ-ийн хурлаар 2021 оны 06 сарын 24-ны өдөр т/21-11-07 дугаар дүгнэлтийг үндэслэн 2021 оны 07 сарын 21-ны өдөр т/141 тушаалаар баталсан байна.

1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч	“Танлон” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9019010072
Регистрийн дугаар	2772388
Хаяг	Улаанбаатар, Сүхбаатар, 5-р хороо 50 мянгат, 8-5
Утас	

1.3 Төслийн хүчин чадал

“Танлон” ХХК-ийн техникийн даалгаврын дагуу жилд 16.0 мян.м³ шавар олборлох бөгөөд тус хүчин чадлаар ордын баттай ба бодитой зэрэглэлийн нөөцийг бүрэн ашиглахад 110 жил шаардагдахаар байна. Уг тодотгол ТЭЗҮ-д баттай А зэрэглэлийн нөөцийг бүрэн ашиглах буюу эхний 15 жилд 237.0 мян.м³ тоосгоны шавар олборлохоор тооцлоо. Цаашид уурхайн хүчин чадал болоод ашиглах тоног төхөөрөмжүүд өөрчлөгдөх, мөн 5 жил болоод дахин тодотгол хийлгэх шаардлагатай болно.

1.4 Ашиглалтын систем

“Харганат-3” тоосгоны шаврын орд нь уул-геологийн тогтоц энгийн, хөрс хуулалт багатай, гидрогеологийн нөхцөлийн хувьд хүндрэлгүй ил аргаар олборлоход хялбар орд юм. Чулуулгийн физик-механикийн шинж чанар, олборлолтын арга, механикжуулалтын бүтэц, тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт зэргийг харгалзан ил уурхайн аргаар, утгуурт ачигч-автосамосвалын хослол бүхий авто тээвэртэй, дотоод овоолготой ашиглалтын системээр олборлоно.

1.5 Дэд бүтэц

Дэд бүтцийн хувьд орд нь сайн хөгжсөн бүсэд оршдог, Улаанбаатар хоттой хатуу хучилттай зам болон төмөр замаар холбогдсоноос гадна өндөр хүчдэлийн шугам, телефон холбоотой.

“Харганат-3” шаврын орд орших Налайхын хотгорын хэмжээнд сүүлийн жилүүдэд хятад, монголын 10 гаруй тоосгоны үйлдвэр ажиллаж байна.

Уурхайн барилга байгууламж, дэд бүтцийн бүрэлдэхүүнд:

- Ажилчдын байр
- Оффис
- Гүний худаг
- Дэд станц
- Эхний 15 жилийн хугацаанд ашиглахаар нөөц тогтоогдсон 6 га талбай
- Үржил шимт хөрсний гадаад, дотоод овоолго

- Тодорхой зайд байрлах шаврыг боловсруулах, шатаах иж бүрэн тоосгоны үйлдвэр үйлдвэрт хамаарах тоосго хатаах талбай бусад объектууд хамаарна.



Зураг №. 1 Төслийн талбайн дэд бүтцийн зураг

Усан хангамж: Тоосгоны үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглэгдэх болон ажиллагсдын ахуйн хэрэгцээний усыг өөрийн талбайд байрлах 5л/сек ундаргатай гүний худгаас хангана. Худгийн шахуургын цахилгааны хэрэглээг үйлдвэрлэлийн цахилгааны нийт хэрэглээнд оруулан тооцсон болно.


Худгаас усыг ЭЦВ-8 маркийн усны насосоор соруулан 100 мм диаметртэй хоолойгоор тоосгоны үйлдвэрт хүргэнэ.

Цахилгаан хангамж: “Танлон” ХХК нь “Харганат-3” тоосгоны шаврын ордын талбайд “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ”ХК-иас олгосон техникийн нөхцөлийн дагуу 400 кВт чадалтай трансформатор бүхий КТПН шинээр суурилуулан төвлөрсөн сүлжээнээс кабель шугам татаж цахилгаан хангамжийн асуудлыг бүрэн шийдсэн байна.

Цахилгаан үүсгүүрийн газардуулгын тооцоо:

Аянга хамгаалалтын газардуулга: Барилга байгууламжийн болон түүний тоноглолыг аянгын болон дотоод хэт хүчдэлээс хамгаалах зориулалттай газардуулгыг хэлнэ.

Газардуулгын тооцоог хийхийн тулд бүх газардуулагчийн урт ба өргөн, диаметр, газардуулгын талбай, электродын газарт суулгах гүн, хөрсний хувийн эсэргүүцэл, газрын богино залгааны гүйдэл зэрэг




Зураг №. 2 Хоёр босоо аянга зайлуулагчийн хамгаалах бүс

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙН ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газар зүйн нөхцөл

Хүснэгт №. 1 Төслийн талбайн координат

№	Уртраг	Өргөрөг
1	107° 17' 46.38"	47° 45' 41.77"
2	107° 17' 35.38"	47° 45' 41.77"
3	107° 17' 35.37"	47° 45' 29.78"
4	107° 17' 27.37"	47° 45' 29.78"
5	107° 17' 27.37"	47° 45' 11.78"
6	107° 17' 9.37"	47° 45' 11.78"
7	107° 17' 9.37"	47° 45' 4.06"
8	107° 17' 19.37"	47° 45' 3.84"
9	107° 17' 19.37"	47° 45' 6.78"
10	107° 17' 25.37"	47° 45' 6.78"
11	107° 17' 25.37"	47° 45' 2.78"
12	107° 17' 46.37"	47° 45' 2.78"



Зураг №. 3 Харганат-3 ашиглалтын тусгай зөвшөөрлийн байршлын зураг

Физик газар-зүйн: Уул зүйн хувьд ордын район нь Хэнтийн уулархаг мужийн баруун урд хэсэгт Налайхын хотгорт хамаарагдана. Энэхүү хотгорын туйлын өндөржилт далайн түвшнээс дээш 1400-1420 м (ордын талбайн хэсэгт) байна. Орд

байрлаж буй хотгор нь баруунаас зүүн тийш чиглэлтэй, гонзгойдуу хэлбэртэй төв хэсэгтээ хонхордуу, төв, зүүн талдаа тэгшивтэр талархаг гадаргуу үүсгэжээ.

Усан сүлжээ: Усан сүлжээний хувьд ордын хойгуур Туул гол урсан өнгөрөх ба Туул голын усны зардал маш тогтворгүй, зун борооны үед голын усны түшингийн хоногийн хэлбэлзэл 50-60 см-ээр дээшилдэг. Туул голын усны урсгалын хурд 1.2 м/сек, голын усны өргөн 30-70 м гүн нь 0.8-3.5 м, олон жилийн ажиглалтын мэдээгээр голын усны зардлыг 101.0 м³/сек гэж тогтоосон байна. Мөн уулнаас эх авсан жижиг гол горхи Туул голд цутгадаг. Ордын зүүн талаар Налайхын гол урсах ба голын хөндийд Бүс нуур, бусад жижиг давст нуур тойрмууд тохиолдоно.

Цаг уур: Цаг уурын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай. Улирлын болон хоногийн температур эрс хэлбэлзэлтэй, атмосферийн тунадасны хэлбэлзэл 120-220 мм бөгөөд жилийн дунджаар 200 мм хүрнэ. Анхны цас 9-р сарын 15-ны үеэр, сүүлчийн цас 5-р сарын 15-ны үеэр орох жишээтэй. Хамгийн халуун 7-р сард, хамгийн хүйтэн нь 1-р сард болдог. Хамгийн их хур тунадас унадаг улирал нь зун, хамгийн бага унадаг улирал өвөл юм.

Өвөл хөрс нь 3-5 м гүн хөлддөг. Цэвдэгшил нэлээд тархалттай, газрын тогтоц чулуулгийн литологийн найрлагаас хамаарч нам дор газар 1.5-2.0 м, өндөрлөг хэсэгт 3.5-5.0 м-т тохиолдоно. Ордын район нь газар хөдлөлтийн VII-VIII бүсэд багтана.


2.2 Уурхайн тээвэр

ТЭЗҮ боловсруулах техникийн даалгавар болон уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу жилд дунджаар 1.3 мян.м³ хөрс хуулж, 16.0 мян.м³ тоосгоны шавар олборлоно. Тээвэрлэлтийн зай дунджаар 0.5 км байна.

**УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДАХЬ “ХАРГАНАТ-3”
ТООСГОНЫ ШАВРЫН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2.3 Овоолгын ажил


Ашиглалтын хугацаанд нийт 19.6 мян.м³ хөрс хуулж дотоод овоолгод байршуулна. Жилд дунджаар 1.3 мян.м³ хөрс хуулах бөгөөд орд нь хэвтээ уналтай, бага гүнтэй тул ашиглалтын эхний жилээс эхлэн дотоод овоолго хийх боломжтой болж байна.



Зураг №. 4 Бульдозерын овоолго үүсгэх схем

2.4 Тоосго үйлдвэрлэх ерөнхий дамжлага

Тоосго үйлдвэрлэх шавар нь хүлээн авах бункерт орон, туузан дамжлагаар анхны бутлагчаар дамжин, том хэмхдэсийг ялгах торон эргэлтэт шигшүүрээр шигшигдэж




Зураг №. 5 Тоосго үйлдвэрлэлтийн үндсэн дамжлагын дэс дараалал

УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДАХЬ “ХАРГАНАТ-3” ТООСГОНЫ ШАВРЫН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

нэмэгдэл хольцын хамт (нүүрс, ус) холигч болон шахагч (пресс), хэрчигч дамжлагуудаар дамжин түүхий тоосго болон гарна. Тоосго нь 200мм*100мм*мм50мм хэмжээтэйгээр хэрчигдэн хүлээн авах дамжлагаар дамжин тэдгээрийг жижиг оврын тээврийн хэрэгслээр тээвэрлэн хатаах талбайд хүргэнэ. Хатаах талбайд түүхий тоосгыг хураан байрлуулж, хур тунадас, салхины нөлөөллөөс хамгаалах арга хэмжээ авч 2-3 хоногийн хугацаанд хатаасны дараа шатаах баюуд оруулан эцсийн бүтээгдэхүүн болгоно..

Тоосго үйлдвэрлэх технологийн тоо чанарын схем


“Харганат-3” ордын тоосгоны шаврын шинж чанарын тодорхойлолтыг лаборатори-технологийн, физик механикийн хураангуй шинжилгээ, цацраг идэвхт элементүүдийн агуулалт, радиын эквивалентыг тогтоох зэрэг 11 сорьцын үр дүнгээр хийсэн байна. Эдгээр шинжилгээний үр дүнгээр “100”-аас дээш маркийн нүхтэй болон ердийн тоосго үйлдвэрлэх боломжтой гэж тооцон одоо ажиллаж байгаа “Харганат-3” тоосгоны шаврын ордын технологийн тоо чанарын схемийг дараах зурагт үзүүлэв.



Зураг №. 6 100-аас дээш маркийн ердийн тоосго үйлдвэрлэх технологийн тоо чанарын схемийн бүдүүвч

2.5 Тоосго үйлдвэрлэх тоног төхөөрөмж

Төсөл хэрэгжүүлэгч компани нь Налайх дүүрэгт 2004 оноос хойш тоосго үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тоосго боловсруулах технологийн дамжлагуудад БНХАУ-д үйлдвэрлэсэн тоног төхөөрөмжүүдийг хэрэглэж ирсэн. Бид энэхүү төсөлд өмнө нь ашиглаж байсан тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар тусгасан. Үүнд:



Зураг №. 7 Тоосго үйлдвэрлэлтийн дамжлага схем

Байгалийн аргаар тоосго хатаах: Байгалийн аргаар тоосгыг хатаах саравч нь 18*20м өргөн 50м урт хэмжээтэй, модон каркас ашиглан полиэтилэн хальсаар хучсан гадна болон дотор талдаа борооны ус зайлуулах сувагтай.

БҮЛЭГЗ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Харганат-3” тоосгоны шаврыг орд бүхий тоосгоны үйлдвэр –ийн талбай нь Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт хэрэгжинэ. Налайх дүүрэг нь Нийслэлийн Баянзүрх дүүрэг, Төв аймгийн, Сэргэлэн, Эрдэнэ сумтай хиллэдэг байна. Налайх дүүрэг нь 68,7 мянган га нутагтай, 8992 өрхийн 32513 хүн амтай, Засаг захиргааны 7 хороо, 40568 малтай. Нийслэл хоттой авто болон төмөр замаар холбогдсон байна.

2.1 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

2.1.1 Агаарын чанар

- Бүтээгдэхүүн тээвэрлэх үеийн машины утаа тортог, замын тоос үүсэх
- Хүдэр боловсруулах үед үүсэх тоосжилт
- Барилга байгууламжийн орчмын шимт хөрс элэгдэж эвдэрснээс ургамлын нөмрөг талхлагдсанаас тоосжилт үүсэх
- Хатуу хог хаягдлыг цаг тухайд нь зайлуулаагүйгээс ялзарч муудан, үнэр орсноор агаар орчныг бохирдуулах зэрэг нөлөө үзүүлэхээр байна.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Машин техникийг тогтмол үзлэгт хамрагдуулж байх, янданд шүүлтүүр тавих
- Зам талбайг тогтмол усалж чийгшүүлж байх
- Ажилчдын амрах байр сууцны гадна талбайг зүлэгжүүлж тохижуулж агаарын чанарыг сайжруулах
- Хог хаягдлыг цаг тухай бүрд ачуулж, ангилах ялгаж байх
- Төсөл хэрэгжих бүхий хугацаанд агаарын тоос болон хорт бодисыг хэмжилтийн цэг бүр дээр тогтмол хийж байх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой юм

2.1.2 Хөрсөн бүрхэвч

Төслийн зүгээс хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт дор дурдсан сөрөг нөлөөллүүдийг үзүүлэхээр байна. Үүнд:

- Барилга байгууламжийн ойр орчмын шимт хөрс элэгдэж, эвдэрснээс ургамлан нөмрөг талхлагдах
- Ачиж тээвэрлэх үеийн машин техникийн хөдөлгөөнөөс хучилтгүй зам талбайн хөрс элэгдэж, эвдрэх
- Олон салаа зам гарган зорчих
- Машин техникийн эвдрэл гэмтлээс үүдэн тос, тослох материалын асгаралтаас хөрс, ус бохирдох
- Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаяагүй, мөн ангилан ялгаагүйгээс болж хөрсийг бохирдуулах
- Ажилчдын ариун цэврийн газар болон хоолны газраас гарах шингэн хог хаягдлын байгууламж байхгүй, тэдгээрийн эвдрэл гэмтэл, дүүрэх зэрэг асуудлаас хөрс бохирдох

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Ажилчдын амрах байр, хоолны газар, оффис зэрэг барилга байгууламжийн гадна талбайг зүлэгжүүлэх, машин техникийн засварын газар болон тос тослох материалын агуулахын гадна талбайг цементлэх
- Олон салаа зам гаргахгүй байх, зам талбайн тэмдэгжүүлэлт хийх
- Уурхайн гадаад болон дотоод тээврийн замыг хатуу хучилттай болгох
- Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаях, цаг тухай бүрд ачуулах, ангилан ялгаж байх
- Цэвэрлэх байгууламж болон ариун цэврийн байгууламжийг байгаль ээлтэй технологийг сонгон ашиглах эдгээрийн эвдрэл гэмтлийг шалгаж байх
- Уурхайн машин техник төхөөрөмжийн үзлэг шинжилгээг тогтмол хийж байх

2.1.3 Гадаргын болон газрын доорх ус

Атмосферийн хур тунадас энд харьцангуй бага унадаг бөгөөд үүний ихэнх хувь нь зуны төгсгөл болон намар бороо маягаар ордог байна. Эрэл хайгуулын ажлын явцад өрөмдсөн 50-70 м хүртэл гүнтэй цооногоос үзвэл ихэнх нь хуурай байх ба 40-50 м хүртэл гүнтэй карьераар олборлолт хийхэд, төдийлөн гидрогеологийн хувьд хүндрэл учрахгүй гэж үзсэн.

Гэвч олборлолтын явцад 30-35 метрийн гүнээс ус илэрч байна. Иймд цаашид гидрогеологийн судалгааг дахин нарийвчлан хийх шаардлагатай.

Бас дээр нь ахуйн бохир ус болон хог хаягдлыг зөв байршуулаагүй мөн орчны цэвэрлэгээ хийгээгүйн улмаас гадаргын болон хөрсний усыг тодорхой хэмжээгээр бохирдуулж болзошгүй.

2.1.4 Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл

Ажиллагсдын ихэнх нь дуу чимээ ихтэй, температурын эрс өөрчлөлттэй нөхцөлд ажиллахаар байгаа тул мэргэжлээс шалтгаалах өвчлөлд хялбар өртөх магадлалтай юм. Түүнчлэн хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, зориулалтын ажлын нормт хувцасны хангалт, ашиглалтад анхааралтай хандаагүйгээс үйлдвэрлэлийн осолд өртөх магадлалтай байна. Байгалийн гэнэтийн аюул осолд өртөх болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөх, техник хэрэгслийн элэгдэл эвдрэлээс сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хугацаанд хамрагдуулж байх
- Эрүүл ахуй аюулгүй ажиллагааны заавар зөвлөмжийг өдөр бүр өгч байх
- Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэл болон зориулалтын ажлын хувцсаар хангах
- Галын аюулгүй ажиллагаа болон гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах
- Ажилчдыг хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийг чанд сахин мөрдүүлэх тал дээр хяналт тавих

2.1.5 Ургамлан нөмрөг

Хүнд машин техникийн хөдөлгөөнөөр орчны ургамлан бүрхэвч алдагдах, ажиллагсад зориудын бус замаар явах, анхаарал болгоомжгүйгээс гал түймэр гарах зэрэг нь ургамлан нөмрөгт нөлөөлөн, түүний төрөл зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах (хог ургамал ихсэх), зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Ажилчдын амрах байр, хоолны газар, оффис зэрэг барилга байгууламжийн гадна талбайг зүлэгжүүлэх, машин техникийн засварын газар болон тос тослох материалын агуулахын гадна талбайг цементлэх
- Амрах байрнаас хоолны газар хүрэх зам гэх мэт явган хүний замыг нэг маршрутаар болгож цементлэн хашиж аль болох унаган ургамлыг нь гэмтээхгүй байх
- Гадна талбайг тохижуулах хашиж хамгаалах, тогтмол усалж арчилж байх
- Ажилчдын амрах байр, хоолны газар, оффис машин техникийн засварын газар болон тос тослох материалын агуулахын зэрэг барилга байгууламжид галын аюулгүй ажиллагааны буланг хийх ажилчдад хэрэглэх заавар зөвлөгөө санамжийг тогтмол өгөх, сургалт зохион байгуулах

2.1.6 Амьтны аймаг

Төслөөс амьтны аймагт нөлөөлөх шууд нөлөөлөл байхгүй. Төсөл хэрэгжих газар тээврийн хэрэгсэл, хүний хөдөлгөөн ихсэж, дуу чимээний нөлөөлөл зэргээс жижиг амьтад дайжих, амьдрах орчин хумигдсан. Харин ногоон байгууламжийг байгуулснаар төслийн ойр орчмын талбайд тархах зарим амьтдад амьдрахад эерэг нөлөөлөл үзүүлж болох юм.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Хөрсийг зүй зохистой ашиглах, олон салаа зам гаргахгүй байх, тогтсон нэг замаар тээврийн хэрэгслүүдийг зорчуулах.
- Ховор амьтадыг устахаас хамгаалж өөр газар шилжүүлэх болон биотехникийн арга хэмжээ авах талаар судалгаа хийх, шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн байгуулахын зөвлөмж авч хэрэгжүүлэх
- Уулын малталт, овоолгыг ан амьтанд аюулгүй байхаар байрлуулах
- Биологийн олон янз байдлыг хамгаалах төлөвлөгөөг боловсруулах

2.1.7 Нийгэм эдийн засаг

Төслийн үйл ажиллагаанаас нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага ба аливаа болзошгүй нөлөөлөл нь хүний анхаарал, болгоомжгүй, хариуцлагагүй үйл ажиллагаанаас шалтгаална.

Төсөл хэрэгжих хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авто машин болон өөрөө явагч механизмын албан татвар, эдэлбэр газар ашигласны төлбөр болон бусад татвар төлбөрийг улс болон орон нутгийн төсвийн санд оруулах бөгөөд төсөл хэрэгжсэнээр орон нутагт шинэ ажлын байр нэмэгдэх боломжтой юм.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм. “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн түүнийг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллага-үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж боловсруулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тухайн төсөл хэрэгжүүлэгч хүлээхээр тусгасан байдаг. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлан төсөл хэрэгжүүлэх зөвшөөрлийг олгох, жил бүрийн хэрэгжилтийн тайланг хянаж, дараа жилийн төлөвлөгөөг батлах замаар уг төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж байхаар тус тус зохицуулсан билээ. Мөн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих эрхтэй бөгөөд тэдгээрт холбогдох мэдээллээ ил тод болгох, тодорхой хуваарийн дагуу хяналт хийх боломжийг бүрдүүлэх шаардлага мөн тавигдсан байдаг.

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө		Зардал (сая.төг)
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1.000.000
		Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1.100.000
1.1		Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	700,000
1.2		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	500,000
1.3		Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	410.000
2	Орчны хяналт шинжил	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	286,000
2023 оны 1жилийн зардал			4.000.000

УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДАХЬ “ХАРГАНАТ-3” ТООСГОНЫ ШАВРЫН
ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үндсэн зорилго нь “Танлон” ХК-ийн “Харгана-3 тоосгоны шаврын ордыг ил аргаар ашиглах төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчин болон төслийн ажилчид, ойр орчмын оршин суугчид, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, тухайн орчныг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, тус төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэхэд оршино Ингэхдээ, төсөл хэрэгжүүлэгч тухайн арга хэмжээ бүрийг хэрэгжүүлж болохуйц, бодиттой арга хэмжээг төлөвлөн тусгахыг эрхэм болголоо. Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2023 оны 1 жилийн хугацаанд менежментийн төлөвлөгөөний ажилд нийт **4.000.000**төг зарцуулахаар төсөвлөгдсөн байна.

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөлийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян.төг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
1	Агаар	Олборлолтын үед гарах тоосыг усалгаа хийх	Үйл ажиллагааны турш	-	-	-	-	Жил бүр	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008 MNS(ISO)13688 :2000 MNS3306:1991 MNS5620:2006 MNS5623:2006 MNS5388:2004 MNS5389:2004
2	Хөрс болон ургамлан бүрхэвч	Төслийн үйл ажиллагааны үед тос, тослох материалыг ил задгай хаяхгүй байх сургалт явуулах	Төслийн талбай	-	-	-	-	Жил бүр	

УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДАХЬ “ХАРГАНАТ-3” ТООСГОНЫ ШАВРЫН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3		Хөрсөн бүрхэвчийн чанарын өөрчлөлт, элэгдэл эвдрэлийг тогтмол хянах	Тариалнгийн талбай бүхэлдээ	-	-	-	-	Жил бүр	
4		Шаардлагагүй газар ухаж сэндийчихгүй байх	Үйл ажиллагааны явцад	-	-	-	-	Жил бүр	
5		Бэлэн болсон тоосгын эмх замбараатай хураах	Үйл ажиллагааны хугцаанд	-	-	-	-	-	
Нийт 1.0 сая.төг									

БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал мян,төг	Хэрэгжүүлэх хугцаа ба давтамж	Баримтлах эрх зүй баримт бичиг
1	Төслийн талбайд ногоон байгууламжтай болсоноор агаарын тоосжилт буурах юм.	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд төслийн талбай болон үйлдвэрийн орчинд мод тарих	Төслийн талбай	-	-	-	-	Үйл ажиллагааны явцад	MNS 3985:1987 Байгаль хамгаалал. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтийн
2	Техникийн нөхөн сэргээлт	Техникийн нөхөн сэргээлтийг 0.2 га талбайд хийх	Төслийн талбай	-	-	-	-	Үйл ажиллагааны явцад	
3	Биологийн нөхөн сэргээлт	0.2 га талбайд хийх	Төслийн талбай	-	-	-	-	Үйл ажиллагааны явцад	
4	Нийслэлийн санал	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэрт нэгдсэн зохион байгуулалтаар шилмүүст мод тарих						Үйл ажиллагааны явцад	
Нийт 1100.0 сая.төг									

БҮЛЭГ 7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч нь олборлолтын явцад археологи, палеонтологи, түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл уулын ажлыг зогсоож дүүргийн ЗГТГ, мэргэжлийн зохих байгуулагт яаралтай хандана. Одоогийн байдлаар олборлолтын явцад ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдоогүй байна.

УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДАХЬ “ХАРГАНАТ-3” ТООСГОНЫ ШАВРЫН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах жрх зүйн баримт бичиг
1	Байгалийн давагдашгүй хүчин зүйл болж гал гарч химийн бодис галд өртөж шатвал аюултай нөхцөл байдал үүснэ.	Байгаль хамгаалал, болзошгүй гал түймэрээс урьдчилан сэргийлэх талаар ухуулга, сурталчилгааны самбар хийж байрлуулан, тухай бүрд нь шинэчилж байх	Төслийн үйл ажилгааны хүрээнд	-	100,0	100,0	Жил бүр	MNS5566:2005. Аж ахуйн нэгж байгууллагад зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн шаардлага
2		Галын багаж хэрэгсэл авч ашиглахад бэлэн байдлаар байрлуулах (амьсгалын нэг бүрийн хамгаалалтын аппарат, галын хор, гал унтраагч, усан шүршүүр, гал унтраах хуурай хэрэгсэл, хөөс, нүүрсхүчлийн хий гэх мэт)	Төслийн үйл ажилгааны хүрээнд	-	350,0	350,0	Жил бүр	
3		Ажиллагсдыг осол аваар, галын аюулаас хамгаалах арга хэмжээнд сургах ажлыг зохион байгуулан явуулах	Төслийн үйл ажилгааны хүрээнд	-	250,0	250,0	Жил бүр	
					Нийт 700,000			

БҮЛЭГ 9. ХОГ, ХАЯГДАЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдал ангилах	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Айхуйн	Хаягдлыг ил задгай хаяхгүй байхыг хэвшүүлэх	Төслийн талбайд	-	Сумын ТҮК-д Нийлүүлэх	-	-	Үйл ажиллагааны хугцаанд	Хог хаягдлын тухай хууль
2		Ангилан ялгаж тус тусад нь хийх савтай болгох	Төслийн талбайд	-	50,0	-	250,0	Үйл ажиллагааны хугцаан	
					Нийт 500 000				

БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
Хөрс								
1	Хөрсний механик бүрэлдэхүүн	Төслийн талбайн нэг цэг сонгон хөрсний шинжилгээ хийлгэх.	2023 он	Жилд 1 удаа	70,0	140,0	Хөрсийг агрохими, хүнд мяталл, эрүүл ахуй, механик бүрэлдэхүүний шинжилгээг хийлгэнэ	химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга,
2	Хөрсний агрохимин үзүүлэлт							
3	Хөрсний хүнд металлын үзүүлэлт							
4	Хөрсний эрүүл ахуйн үзүүлэлт							
Агаар								
	Агаар	Төслийн талбайн нэг цэг сонгон шинжилгээ хийлгэх.	2023 он	Жилд 1 удаа	100,0	200,0	Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх Агаарын бохирдлын (NO ₂ , SO ₂ , CO, Тоос, H ₂ S ₃ , NH ₃) шинжилгээ хийлгэж байх. БОШТЛ-ын багажаар хийнэ	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколоримтерийн арга MNS 5013:2009 Дизель хөдөлгүүртэй
5	Дуу шуугиан		2023 он	Жилд 1 удаа				

УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДАХЬ “ХАРГАНАТ-3” ТООСГОНЫ ШАВРЫН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

								автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга
Усны шинжилгээ								
6	Усны ерөнхий үзүүлнлт	Усны эх үүсвэрээр	2023	Жилд 1 удаа	46.0	46.0	Усны чанар: рН, ууссан нийт давс (жингийн аргаар), нийт хатуулаг (CaCO3), Ca, Mg, Na, K, SO4, NO2, NO3, NH4, As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni, үнэр, өнгө, нүүрсустөрөгчид (нефть бүтээгдэхүүний бохирдол)	Усны хяналт шинжилгээ: Усны чанар: рН, ууссан нийт давс (жингийн аргаар), нийт хатуулаг (CaCO3), Ca, Mg, Na, K, SO4, NO2, NO3, NH4, As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni, үнэр, өнгө, нүүрсустөрөгчид (нефть бүтээгдэхүүний бохирдол)
Нийт 286,000								

**БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Харилцсан албан тушаалтан	Тайлбар
			2023он				
			Сар 5	Сар 3	Сар9		
1	Ажилчдад байгаль орчныг хамгаалах талаар сургалт зохион байгуулах	-	+	-	+	Байгаль орчны мэргэжилтэн	
2	Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн журам гарган ажилчдад мөрдүүлэн ажиллах.	Үйл ажиллагааны зардлаар	+	+	+	ХАБ –ийн мэргэжилтэн болон жхүүл ахуйч	
3	Гал түймрээс урьдчилан сэргийлэх багаж хэрэгсэл байрлуулах.	-	+	+	+	Захирал	
4	Осол эрсдэлийн төлөвлөгөө боловсруулах.	-	+	+	+	Захирал	
			Нийт 310.0				

**БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ
НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ**

№	БОМТ, хэрэгжилтийг оролцогч талууд	БОМТ-ний тайлагнах	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Налайх дүүрэгт танилцуулж,хэлэлцүүлнэ.	БОМТ-ний тайлагнах	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж бичвэр хэлбэрээр сумдын засаг захиргаанд хүргүүлнэ.	БОМТ-ний биелэлт	БОМТ-ний хэрэгжилтийн явцад орон нутгийн засаг захиргааны байгууллагууд болон оршин суугчдад танилцуулна.	-	Байгал орчны мэргэжилтэн болон захирал сумын засаг захиргааны ажилчид	Налайх дүүргийн засаг захиргаа
Нийт 100.0								